



БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ХҮРЭЭМАРАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 12 өдөр

Дугаар ААБ

Дэлгэрмөрөн

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт, Улсын Онцгой комиссын 2022 оны 03 сарын 23-ны өдрийн 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Малын гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 2022 оны 04 дүгээр сарын 18-ны өдрөөс 05 дугаар сарын 08-ны дотор зохион байгуулсугай.

2. Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, хяналт тавих ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, дархлаажуулалтын төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дархлаажуулалтын ажлыг тогтоосон хугацаанд чанартай зохион байгуулж, багийн нутаг дэвсгэр байгаа үхэр сүргийг бүрэн хамруулах, шаардлагатай хашаа хороо, хүн хүчээр хангах, зар мэдээг түргэн шуурхай хүргэж ажиллахыг Багийн Засаг дарга нарт, хариуцсан багийн малд дархлаажуулалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэхийг мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжийн эмч нарт, Дархлаажуулалтын ажлын хугацаа, гүйцэтгэлийн чанарт байнгын хяналт тавьж, дүн мэдээг танилцуулж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (С.Ганбат) тархвар зүйч (Ш.Сэр-од)-д нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (Д.Баярсайхан)-д даалгасугай.

ДАРГА



С.СУМЪЯАБАЗАР

D /bichig hereg/ Zahiramj -2022 on

642201047